| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 178 | 3.4.2 Уур амьсгалын өөрчлөлт | 3.4.2.9 Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хот, суурин газруудад яндангүй бүс байгуулж, эрчим хүч, усны хангамж хэрэглээтэй амины орон сууцны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ | 993 | Аймгийн төвүүд болон хот, суурин газрын агаарын чанарыг сайжруулах яндангүй бүсийг тогтоож, мөрдүүлэх | Тухайн жилийн арга хэмжээний хэрэгжилт, хувь | - | 100 | | | Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмын төслийг боловсруулан, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2025 оны 03 сарын 24-ний өдөр хэлэлцүүлж, МУБОУАӨ-н яамны 2025.04.23-ний өдрийн 01/1937 дугаартай журмын төсөлд санал хүргүүлэх тухай албан бичгийн дагуу Журмын төслийн 2.1.1, 2.1.9, 3.1.2, 3.1.4 зэрэг заалтад тус тус саналыг тусган хамтарсан тушаал, зөвшөөрлийг баталгаажуулахаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 05 сарын 22-ны өдөр 01/3332 тоот албан бичгээр хүргүүлж, батлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Яндангүй бүсийн хилийн заагийг тодорхойлж, бүсэд мөрдөх журмын төслийг батлуулахаар хүргүүлсэн болно. | | 2,500.00 | Улсын болон орон нутгийн төсөв, Гадаадын зээл, тусламж | | | НАОБТГ |
| 180 | 3.4.3 Ногоон эдийн засаг ногоон хөгжлийн загвар | 3.4.3.3 Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ | 997 | Агаарын чанарыг хянах иж бүрэн лаборатори байгуулах, хяналтыг сайжруулах | Барилгын ажлын гүйцэтгэл, хувь | - | 30 | | УБ | 2020-2025 онуудад агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хяналт хийх иж бүрэн лабораторийн барилгыг шинээр барих хөрөнгийг шийдүүлэхээр жил бүрийн төсөвт тусгах санал хүргүүлсэн боловч 2025 оны төсөвт суугдаагүй тул тус ажил хойшлогдсон | | 500.00 | Улсын болон орон нутгийн төсөв | | | НАОБТГ |

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 13-ний өдрийн 01/38 дугаар албан бичгийн 2 дугаар хавсралт

2025.06.12

## Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт

| Д/д | ТЕЗ-ийн үр дүн | Хөтөлбөрийн үр дүн | Бодлогын үндэслэл | Төсөл, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь | Төсөл, арга хэмжээний хэрэгжилт | Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл | Батлагдсан төсөв | Батлагдсан эх үүсвэр | Санхүүжилтийн гүйцэтгэл | Санхүүжилтийн эх үүсвэр | Хариуцах байгууллага | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 1.10.Байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. | 1.10.1.Байгаль орчинд ээлтэй, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | МУХТЖҮЧ-2.5.3, 4.2.13, 9.2.3, ЗГҮАХ-3.4.2.9 | 1.10.1.1.Агаар, орчны бохирдлыг бууруулах ногоон төсөл, үйл ажиллагааг дэмжих | Цахилгаан халаалтад бүрэн шилжсэн айл өрх | Тоо | 7,890 | 25,000 | 51080 | 100 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 15-ний өдрийн "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 133 дугаар тогтоолын хүрээнд "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах ногоон бүсийн 2025-2026 онд цахилгаан болон бүх төрлийн хийн халаагуурт шилжүүлэх айл өрхийн байршлыг тогтоох төслийг боловсруулан 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/367 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газарт хүргүүлсэний дагуу, 2025.06.10-ний өдрийн 01/3788 дугаартай албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх тухай хүсэлтийг хүргүүлээд байна. Уг тогтоолын хүрээнд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн "Үндэсний хорооны гишүүдэд чиглэл өгөх тухай" 04 дүгээр тогтоолыг Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах ногоон бүсийн 2025-2026 онд цахилгаан болон бүх төрлийн хийн халаагуурт шилжүүлэх айл өрхийн байршлыг хавсралтаар баталж, уг ажилтай холбогдуулан цахилгаан болон хийн халаагуурын тоног төхөөрөмжийн холболт, суурилуулалт, засвар үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхэд шаардлагатай гадаад ажилтнуудын ажиллах зөвшөөрөл, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх асуудлыг зохих хууль журмын дагуу шийдвэрлэх, мөн тус ажлыг гүйцэтгэхэд зэвсэгт хүчин, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Дотоод хэргийн их сургуулийн бие бүрэлдэхүүнийг оролцуулахаар шийдвэрлэсэн. Мөн "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд цахилгаан халаагуур болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг төхөөрөмж суурилуулах, тэдгээрийн хэрэглээнд үнийн урамшуулал олгох журам"-ын төслийг боловсруулан НИТХ-ийн 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 25/59 дугаар тогтоолоор батлуулсан болно. | | 140,000.00 | Орон нутгийн төсөв, Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт | | Нийслэл болон Улсын төсвөөр | НАОБТГ НЗДТГ-ХОХ | Тус журмууд батлагдснаар хэрэгжилтийг хангаж ажиллана. |
| 4 | | | МУХТЖҮЧ-2.5.3, 4.2.13, 9.2.3, ЗГҮАХ-3.4.2.10 | | Хийн халаалтад бүрэн шилжих айл өрх | Тоо | 36 | 15,000 | | | Журмын хэрэгжилтийн хүрээнд ногоон бүсэд 170 мянга гаруй өрх хамрагдаж байгаа бөгөөд 2025 онд 51,080 өрхийг цахилгаан болон бүх төрлийн хийн түлшний хэрэглээнд шилжүүлэн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг нэг удаа үнэ төлбөргүй суурилуулж, халаалтын улиралд хэрэглээнд нь үнийн урамшуулал олгохоор төлөвлөөд байна. Агаарын чанарыг сайжруулах ногоон бүсэд хамрагдсан 103090 өрхийг 2025-2028 онд бүх төрлийн хий болон цахилгаан халаагуурт үе шатайгаар шилжүүлэх, үүнээс 2025-2026 онд бүх төрлийн хий болон цахилгаан халаагуурт 51080 өрхийг шилжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан хийн түлшний үнийг тогтвортой байлгах чиглэлээр LPG хийн түлш хадгалах байгууламжийг байгуулах судалгааг болон байршлыг тодорхойлж, Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-тай хамтран журмын хэрэгжилтийг хангаж ажиллах төлөвлөгөө гаргаж ажиллахаар төлөвлөөд байна. | | 80,000.00 | Орон нутгийн төсөв, Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт | | | НАОБТГ НЗДТГ-ХОХ | |

--------